



ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.06.06 № 01/1029

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240101119 дугаартай “Цанхийн зүүн уурхайн нүүрс ачилтын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 11.1-т заасны дагуу дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт: ... хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124050630



Тодруулгын хариу

Тендерийн нэр	Цанхийн зүүн уурхайн нүүрс ачилтын ажил
Тендерийн дугаар	ЭТТХК/20240101119
Тендер зарласан огноо	2024 оны 05 дугаар сарын 08
Тендер нээх огноо	2024 оны 06 дугаар сарын 10
Тодруулга №1	
Тодруулга	Хариу
<p>Манай компани тус тендер шалгаруулалтанд заасан үндсэн техникүүдийг Хятад улс руу захиалчихсан байгаа ба Монголд нийлүүлэгдэх хугацаа нь 2024.06.15-.2024.06.20-ний хооронд нийлүүлэгдэхээр байна. Тус техникүүд нь Монгол улсад орж ирээгүй учраас тээврийн хэрэгсэлийн гэрчилгээ гарч амжихааргүй байна.</p> <p>Холбогдох худалдах худалдан авах гэрээгээр баталгаажуулсан тохиолдолд тухайн техникүүдийг санал болгосонд тооцох уу?</p> <p>Эсхүл зөвхөн тээврийн хэрэгсэлийн гэрчилгээг харгалзан үзэх үү?</p>	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр дамжуулан шалгах тул худалдах, худалдан авах зэрэг гэрээгээр шинэ техник тоног төхөөрөмж худалдан авсан, техник тоног төхөөрөмж тээвэрлэлтийн замдаа ирж байгаа тохиолдлыг үнэлгээнд харгалзан хянан үзэхгүй болохыг мэдэгдэж байна.</p>
Тодруулга №2	
Тодруулга	Хариу
<p>ТШЗ 19.1(1)-т “Утгуурт ачигчийн оператор нь мэргэжил сургалтын гэрчилгээтэй байна”. Ажлын даалгаварын 2.2.1-т “Мэргэжил сургалтын гэрчилгээ гэдэг нь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, эсхүл политехник коллежийн сургалтад хамрагдсан диплом, гэрчилгээ, сертификат, эсхүл үнэмлэх” гэж заасан.</p> <p>Асуулт: Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн сургалтын төвөөс бусад хүнд машин, механизмын сургалтын төвд суралцаж, операторын мэргэжлийн үнэмлэх, сертификат авсан тохиолдолд уг гэрчилгээ, үнэмлэхийг ТШЗ 19.1(1), Ажлын даалгаварын 2.2.1-т заасан “мэргэжил сургалтын гэрчилгээтэй байна” гэсэн шалгуур үзүүлэлтийг хангасан гэж тооцох уу?</p> <p>Жич: Монгол улсад хүнд машин, механизмын операторуудын дийлэнх хувь нь мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн сургалтын төвөөс бусад хүнд машин, механизмын сургалтын төвд суралцаж мэргэжлийн үнэмлэх, сертификатыг авдаг болно.</p>	<p>Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн сургалтын төв болон бусад хүнд машин, механизмын сургалтын төвд суралцаж, операторын мэргэжлийн үнэмлэх, сертификат авсан байж болно.</p>